

**БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛААР МЭДЭЭЛЭЛ АВАХ, ШИЙДВЭР ГАРГАХАД ОРОЛЦОХ,
ЭРХЭЭ ХАМГААЛУУЛАХ КОНВЕНЦ буюу ААРХУСЫН КОНВЕНЦ**

Товч танилцуулга

Аархусын конвенцийн эх сурвалж, хэн, хэзээ, хаана батласан тухай

1992 оны Дэлхийн дээд хэмжээний уулзалтаас батлагдсан “Хүрээлэн буй орчин, хөгжлийн асуудлаарх Риогийн тунхаглал”-ын 10-р зарчмын¹ хэрэгжилтийг хангах үүднээс Аархусын конвенцийг баталсан байна. Монгол улс Риогийн тунхаглалд нэгдсэн улсын нэг.

“Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах конвенц”² буюу Аархусын конвенцийг НҮБ-ын Европын эдийн засгийн комисс (ЕЭЗК) Дани улсын Аархус хотноо 1998 оны 06 сарын 25-ны өдөр баталсан.

2020 оны 2 сарын 18-ны байдлаар тус Аархусын конвенцид Европын холбооны 47 улс нэгдэн орсон байна.³

Аархусын конвенцийн ач холбогдол

Аархусын конвенц нь байгаль орчны шинэ төрлийн гэрээ бөгөөд түүний ач холбогдлыг дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:

- хүний эрх ба байгаль орчны эрхийг холбож өгсөн;
- хойч үеийнхнийхээ өмнө өнөөгийн бидний хүлээх үүргийг хүлээн зөвшөөрсөн;
- холбогдох бүх талуудыг бүрэн оролцуулж чадсан цагт л тогтвортой хөгжилд хүрч болохыг ойлгуулсан;
- байгаль орчныг хамгаалах явдлыг Засгийн газрын үүрэг хариуцлагатай холбон, Засгийн газрыг хариуцлагатай, ил тод байхыг сануулсан;
- төр ба олон нийтийн харилцаанд ардчилсан зарчмыг бэхжүүлсэн.

Хамгийн чухал нь байгаль орчны асуудлаарх олон нийтийн бодит оролцоог төр засгийн түвшинд хүлээн зөвшөөрүүлсэн гэрээ юм.

Түүнчлэн МУ-ын УИХ-аас 2020 оны 5 сарын 13-ны өдөр баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “ардчилал, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх” тухай эрхэм зорилгын 5 дугаар заалт “Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтоож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа

¹“Байгаль орчны аливаа асуудлыг бүх шатанд нь зөвхөн сонирхсон иргэдийн оролцоотойгоор хамгийн оновчтой шийдвэрлэж чадна. Хүн бүр үндэсний хэмжээнд төр засгийн зүгээс авч хэрэгжүүлж буй үйл аажуулаа, үеийнхнийхээ өмнө өнөөгийн бидний хүлээх үүргийг хүлээн зөвшөөрсөн; холбогдох бүх талуудыг бүрэн оролцуулж чадсан цагт л тогтвортой хөгжилд хүрч болохыг ойлгуулсан; байгаль орчныг хамгаалах явдлыг Засгийн газрын үүрэг хариуцлагатай холбон, Засгийн газрыг хариуцлагатай, ил тод байхыг сануулсан; төр ба олон нийтийн харилцаанд ардчилсан зарчмыг бэхжүүлсэн”

²<https://www.unece.org/fileadmin/DAM/env/pp/documents/cep43e.pdf>

³https://www.unece.org/oes/nutshell/member_states_representatives.html

бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болох..." -ыг хэрэгжүүлэхэд шаардагдах процессын журмуудыг боловсруулан хэрэгжүүлэх чадавхийг бий болгоход Аархусын конвенцид нэгдэн орсны ач холбогдол оршино.

Аархусын конвенцийн агуулга

Конвенцийн дагуу байгаль орчны салбарт илүү үр нөлөөтэй, ил тод, хариуцлагатай олон нийтийн оролцоо, түүнийг хангах төрийн байгууллага, албан тушаалтны эрх, үүргээ хэрэгжүүлэх **үндсэн гурван чиглэлийн процессыг** нарийвчлан заасан. Эдгээр нь:

1. байгаль орчны асуудлаар мэдээлэл авах;
2. байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад оролцох;
3. байгаль орчны зөрчигдсөн эрхээ сэргээн хамгаалуулах процесс болно.

Мөн Конвенцид нэгдэн орсон улс орнуудад байгаль орчны асуудлаарх олон нийтийн оролцооны ил тод, тодорхой, тууштай механизмыг бий болгохын тулд шаардлагатай эрх зүйн болон бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосон. Тухайлбал,

- иргэдийн байгаль орчны мэдлэг боловсролыг дээшлүүлэх явдлыг дэмжих;
- байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажиллаж буй байгууллага, холбоод, бүлгүүдийг хүлээн зөвшөөрч, дэмжих бөгөөд энэхүү үүргээ үндэсний хууль тогтоомжид тусган баталгаажуулахыг заасан.

Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах

- “Байгаль орчны мэдээлэл” гэдэгт юуг хамруулж болох тухай нарийвчилсан зохицуулалтыг тусгасан;
- Конвенцийн 4, 5-р зүйлүүдээр мэдээлэл авах эрхийг баталгаажуулан, төрийн албан тушаалтнаас олон нийтэд мэдээлэл өгөх хугацаа, хэлбэр, мэдээлэл өгөхөөс татгалзах үндэслэл, журам зэргийг нарийвчлан зохицуулсан;
- Мэдээллийг төлбөртэй өгч болох ба энэ тохиолдолд төлбөр нь зохих хэмжээнд байна. Түүнчлэн төлбөр төлөх хэлбэр, журмыг олон нийтэд нээлттэй байлгах үүргийг Улс орнууд хүлээх юм;

Конвенцоор Улс орнуудад хүлээлгэсэн бас нэгэн онцлог үүрэг нь **“Байгаль орчны мэдээллийг цуглуулах, олон нийтэд түгээх”** асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтнууд тодорхой үүрэгтэй оролцох явдал юм. Тухайлбал:

- Төрийн албан тушаалтнууд нь байгаль орчны мэдээллийг хадгалан, шинэчилж байх;
- Мэдээлэл түгээх арга хэрэгсэл нь үр нөлөөтэй, практикт нийцсэн байх, орчин үеийн техник технологийн дэвшлийг ашиглан зохих мэдээллийг олон нийтэд түгээх;
- Байгаль орчин, хүний эрүүл мэндэд учрах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахад олон нийтийн хүчийг ашиглахын тулд тэдэнд мэдээлэл

түгээх. Тогтмол хугацаанд байгаль орчны төлөв байдлын мэдээллийг олон нийтэд тайлагнах;

- Мэдээлэлд суурилан - байгаль орчныг харгалзсан сонголт хийх боломжийг хэрэглэгчдэд олгох үүднээс аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар хангалттай мэдээлэл өгөх явдлыг баталгаажуулсан механизмыг бий болгох.

Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангах

- Байгаль орчны асуудлаар (бодлого, стратеги тодорхойлох, хууль тогтоомжийг хэлэлцүүлэх г.м.) шийдвэр гаргах үйл явцын талаарх тодорхой мэдээллийг хамгийн боломжтой хувилбараар аль болох эрт, цаг хугацааг харгалзсан, үр дүнтэйгээр, зохих арга замаар, холбогдох талуудад мэдээлэх үүргийг Улс орнуудад хүлээлгэсэн;
- Байгаль орчны асуудлаар гаргах гэж буй шийдвэртэй холбоотой, олон нийтэд тараах мэдээлэлд юу орж болохыг нарийвчлан тодорхойлсон;

Байгаль орчны зөрчигдсөн эрхээ сэргээн хамгаалуулах

- Иргэн, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын аль нь ч байгаль орчны асуудлаар мэдээлэл авах эрх нь зөрчигдсөн гэж үзвэл энэ талаарх нэхэмжлэлийг шүүхэд болон бусад байгууллагад гаргаж болох ба маргаанаа үнэ төлбөргүй, эсхүл хямд зардлаар шийдвэрлүүлэх боломжийг төрийн зүгээс баталгаажуулах;
- Төрийн байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр, үйл ажиллагаа нь байгаль орчны хуулийг зөрчсөн гэж үзвэл шүүх болон бусад байгууллагад өргөдөл, гомдол, нэхэмжлэл гаргах эрхийг дотоодын хууль тогтоомжоор эрх олгогдсон этгээдүүдэд олгосон. Конвенцийн дагуу байгаль орчны ТББ-үүд нь “байгаль орчны хэрэгт онцгой ашиг сонирхолтой” гэж тооцогдох тул төр засгийн буруу шийдвэр, хууль тогтоомжийн хэрэгжилтийн асуудлаар шүүхийн болон захиргааны байгууллагад гомдол, шаардлага гаргах эрхтэй.

Конвенцид хийсэн нэмэлт өөрчлөлт, протокол

Конвенц хүчин төгөлдөр болж үйлчилж эхэлснээс хойш дараах нэмэлт өөрчлөлт, нэмэлт протоколоор баяжин хүрээ нь тэлэгдсэн.

1. “Генийн өөрчлөлттэй организм (ГӨО)”-ийн талаарх нэмэлт өөрчлөлт⁴

2005 онд Аархусын конвенцид “Генийн өөрчлөлттэй организм”-ийн талаарх нэмэлт өөрчлөлт оруулсан. Уг нэмэлт өөрчлөлтөөр генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах, тухайлбал тариалах зэрэг шийдвэр гаргах явцад иргэдийн оролцоог хангахыг онцгойлон зааж өгсөн. Түүнчлэн тодорхой газар нутгуудад зөвшөөрөгдсөн ГӨО-ыг тариалахыг хориглох, хязгаарлах боломжийг гишүүн улс орнуудад олгодог.

2. “Бохирдуулагч бодисын устгал, зөөвөрлөлтийн бүртгэл (БУШБ)”-ийн протокол⁵

⁴Genetically Modified Organism-Генийн өөрчлөлттэй организм буюу хувиргасан амьд организм, <https://www.unece.org/fileadmin/DAM/env/documents/2005/pp/ece/ece.mp.pp.2005.2.add.2.e.pdf>

⁵ <https://www.unece.org/env/pp/prtr.html>

БУШБ-ийн протокол нь аж үйлдвэрийн болон бусад аж ахуйн үйл ажиллагаанаас үүссэн бохирдуулагч брдисыг бүртгэх үйл ажиллагааг зохицуулна. Өөрөөр хэлбэл бохирдуулагч бодисын тархац, хэлбэр, хэмжээ, хугацаа, эх үүсвэрийн тухай мэдээллийн санг бий болгон нийтэд мэдээлэх, бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлох зэрэг ач холбогдолтой.

Энэ протокол нь орчны бохирдлыг бууруулах чухал хэрэглүүр болдог тул улс орчны байгаль орчны бодлогод олон нийтийн дэмжлэгийг авахад чухал ач холбогдолтой. Түүнчлэн 2030 он хүртэл хэрэгжүүлэхээр НҮБ-ын гишүүн орнуудын өгсөн тогтвортой хөгжлийн амлалтын хэрэгжилтийг үнэлэхэд нэлээд нөлөөтэй.

Уг протокол нь нээлттэй буюу Аархусын конвенцид нэгдээгүй, НҮБ-ын Европын эдийн засгийн комиссын гишүүн бус НҮБ-ын бүх гишүүн улс орнууд уг протоколд нэгдэж болно.

Нийцлийн механизм⁶

Конвенцид нэгдэн орсон улс орнууд авсан үүрэг амлалтаа хэрэгжүүлж, нийцлийг хангахад нь дэмжлэг үзүүлэх олон талт олон улсын гэрээний механизмыг бий болгох хэрэгцээ шаардлага үүссэн. Ялангуяа Конвенцийн нийцлийг шалгахад зөрчилдөөнгүй, шүүхийн бус болон зөвлөлдөх шинж чанар бүхий зохицуулалт шаардлагатай байсан. Эдгээрт үндэслэн Конвенцийн нийцлийн механизмыг бий болгож Нийцлийн Хороог байгуулсан.

Конвенцийн гишүүн улс орнуудын нийцлийг 4 хэлбэрээр шалгадаг. Эдгээрт:

1. аль нэг улс нь өөр улсын нийцлийн талаар мэдээлэл илгээх;
2. аль нэг улс нь өөрийн улсын нийцлийн талаар анхаарч мэдээлэл илгээх;
3. Ажлын алба нь Хорооноос лавлах;
4. гишүүн улсын нийцлийн талаар олон нийтээс нь мэдээлэл хийх зэрэг болно.

Маргааныг хянан шийдвэрлэх

Конвенцийг тайлбарлах, хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Конвенцийн хоёр болон түүнээс олон тооны Талуудын хооронд маргаан үүссэн бол талууд уг маргааныг эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг хичээх бөгөөд маргаан хянан шийдвэрлэх боломжит бусад аргуудыг хэрэглэж болно. Ингэхдээ (а) Олон улсын Шударга ёсны шүүхэд маргааныг мэдүүлэх (б) Конвенцийн II хавсралтад заасан журмын дагуу маргааныг Арбитраар шийдвэрлүүлнэ.

Монгол улс Европын бүсийн энэхүү конвенцид нэгдэн орох боломжтой юу?

Конвенцийн 19-р зүйлийн 19.3 дахь заалтын дагуу Европын холбооны гишүүн бус улсууд нэгдэн орж болох талаар Европын холбоо болон НҮБ-ын хооронд хийсэн тохиролцоотой. Үүний дагуу НҮБ-ын гишүүн аль ч улс энэхүү конвенцид нэгдэж болно.

⁶<https://www.unece.org/environmental-policy/conventions/public-participation/aarhus-convention/tfwg/envppcc.html>

Өмнө хийсэн үйл ажиллаганы товч мэдээлэл:

Хүний эрх хөгжил төв нь Хүний эрхийн нөлөөллийн хөтөлбөрийн хүрээнд 2006 оноос эхлэн уул уурхайн буруутай үйл ажиллагааны улмаас байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөөг арилгах, амин чухал эрх нь зөрчигдсөн нутгийн иргэдийг хамгаалахад чиглэсэн Байгаль орчны нөлөөллийн ажлуудыг хийсээр ирсэн. Энэ хүрээнд хөрс, ус агаарын бохирдол хэрээс хэтэрч, Монгол Улсын иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, цаашлаад амьд явах эрх зөрчигдөж байгаад санаа зовниж Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, зөрчигдсэн эрхийг сэргээх тухай Аархусын Конвенцид (цаашид Аархусын Конвенц гэх) МУ-ыг нэгдэн ороход уриалах нөлөөллийн ажлыг 2008 оноос эхлүүлж, байгууллагын стратегитаа тусгаж ажилласан. 2010 оны НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн түгээмэл тогтмол хэлэлцүүлэгт илгээсэн байгаль орчны эрхийн хэрэгжилтийн тухай мэдээллийн дагуу Монгол улсын засгийн газарт "...шийдвэр гаргах үйл явцыг ил тод болгох, иргэдийн оролцоог хангах, хууль тогтоомжийг олон нийтээр хэлэлцүүлэх бүтэц, зохион байгуултыг бий болгох" зэрэг Аархусын конвенцийн заалтыг хэрэгжүүлэхийг зөвлөсөн болно. 2011 онд Конвенцийг Монгол хэл рүү орчуулсан нь НҮБ-ын Европын эдийн засгийн комиссын веб сайтад байршсан.⁷

Улмаар 2012 онд ХЭХТ нь Монголын байгаль орчны иргэний зөвлөл, Монгол Улсын ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимтай хамтран "Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, зөрчигдсэн эрхээ сэргээлгэх тухай Конвенц буюу Аархусын конвенцид нэгдэн орох ач холбогдол/хэрэгцээ шаардлагын талаар Зөвлөлдөх үүлзалтыг зохион байгуулсан. Уулзалтаар 34-н төрийн бус байгууллага, түүний дотор Монголын байгаль орчны иргэний зөвлөл, түүний гишүүдийн байр суурийг нэгтгэж, тодорхойлсон.

Уг байр суурийг, удалгүй МУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газраас зохион байгуулсан "Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, зөрчигдсэн эрхээ сэргээлгэх тухай Конвенц" буюу Аархусын конвенцийн асуудлаарх олон улсын хурлын үеэр танилцуулж уг Конвенцид Монгол Улс нэгдэх нь байгаль орчноо хамгаалж чадах, иргэдийнхээ зөрчигдсэн эрхийг сэргээх эрх зүйн нөхцлийг бүрдүүлэх боломж олгохыг онцолж Монгол Улсын Ерөнхийлөгчид хүсэлт гардуулсан.

Тухайн үед Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайдаар ажиллаж байсан буюу одоогийн Улсын Их Хурлын Гишүүн, УИХ-ын дарга Г.Занданшатар, тухайн үед Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ажиллаж байсан буюу одоо УИХ-ын гишүүн Д.Цогтбаатар, Монгол улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын дарга асан Ж.Бямбадорж нар тус конвенцид нэгдэх нь зүйтэй гэж үзэж буйгаа тус олон улсын хурлын үеэр илэрхийлж байсан.⁸

2020 оны 10 дүгээр сар 8

⁷ https://www.unece.org/fileadmin/DAM/env/pp/documents/Aarhus_Convention_in_Mongolian.pdf

⁸ <http://www.unece.org/env/pp/news.html>